

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Оюуны ирээдүй сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/106/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	9
5.2 Албан шаардлага.....	10
5.3 Зөвлөмж	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 68

талай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Оюуны ирээдүй сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 22,895.3 мянган төгрөгийн ухаалаг самбар, угаалгын машин, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 591,371.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, сурагчийн ширээ сандал, сургуулийн гадна гэрэл, камержуулалт, 814,472.7 мянган төгрөгийн спорт заал, урлаг заал, ариун цэврийн байгууламжийн их засвар, Засаг даргын нөөц хөрөнгөөс 147,040.5 мянган төгрөгийн сурагчийн ширээ сандал болон урлаг заалны сандал, Дархан сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 11,980.0 мянган төгрөгийн гадна хогийн сав, сандал зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал

4528050154

дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус байгууллага нь Боловсролын газрын даргын 2025 оны 07 сарын 22-ны өдрийн 433 дугаар албан бичгийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлэхтэй холбоотой хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын бүтэц орон тоог батлаагүй үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Оюуны ирээдүй сургууль нь 2025 онд 4 зорилт 102 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96.5 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,368,123,572.13</u>	<u>1,080,558,559.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,047,748,146.78	529,516,786.74
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,047,748,146.78	529,516,786.74
31211	Төрийн сангийн харилцах	2,047,748,146.78	529,516,786.74
33	АВЛАГА	-	162,816.66
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	162,816.66
35	БАРАА МАТЕРИАЛ	320,375,425.35	550,878,955.76
351	Түүхий эд материал	1,282,894.00	1,186,924.00
35130	Эм боох материал	1,282,894.00	1,186,924.00
354	Хангамжийн материал	319,092,531.35	549,692,031.76
35410	Бичиг хэргийн материал	3,496,273.00	2,553,215.00
35420	Аж ахуйн материал	42,163,155.95	196,782,664.95
35450	Барилгын засварын материал	120,000.00	28,192,040.00
35460	Хүнсний материал	-	591,644.00
35470	Бусад хангамжийн материал	273,313,102.40	321,572,467.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,748,760,304.89</u>	<u>14,583,384,142.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,748,760,304.89	14,583,384,142.56
392	Биет хөрөнгө	11,481,724,494.71	12,320,213,150.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,200,723,985.73	12,015,196,694.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,342,147,905.21)	(2,744,449,469.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,883,763,418.19	2,322,609,396.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(583,632,157.62)	(816,050,634.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	742,588,453.29	1,105,308,491.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(249,489,950.74)	(296,032,304.77)
39215	Хуримтлагдсан элэгдэл	929,002,605.78	972,873,405.78
39216	Дуусаагүй барилга, байгууламж	(254,818,819.68)	(356,758,860.91)
39217	Ном	155,734,864.97	117,516,431.88
393	Биет бус хөрөнгө	2,267,035,810.18	2,263,170,992.14
39301	Програм хангамж	22,983,572.00	22,983,572.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,747,761.82)	(12,612,579.86)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,252,800,000.00	2,252,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,116,883,877.02</u>	<u>15,663,942,701.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>16,116,883,877.02</u>	<u>15,663,942,701.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	16,116,883,877.02	15,663,942,701.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,200,550,188.95	4,200,550,188.95
51101	Өмч: - төрийн	4,200,550,188.95	4,200,550,188.95
512	Хуримтлагдсан үр дүн	1,618,861,154.09	1,165,919,978.79
51210	Өмнөх үеийн үр дүн	1,618,861,154.09	1,618,861,154.09
51220	Тайлант үеийн үр дүн		(452,941,175.30)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,297,472,533.98	10,297,472,533.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,116,883,877.02</u>	<u>15,663,942,701.72</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>12,185,480,965.89</u>	<u>11,787,116,853.36</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>1,239,195,665.89</u>	<u>2,145,558,753.36</u>
120	Нийтлэг татварын бус орлого	1,239,195,665.89	2,145,558,753.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	181,039,800.00	178,963,716.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	153,286,100.00	111,645,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,753,700.00	67,318,716.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	985,095,098.99	1,682,187,983.94
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	73,060,766.90	284,407,053.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,946,285,300.00	9,641,558,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,643,722,500.00	9,325,239,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,643,722,500.00	9,325,239,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,562,800.00	316,318,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,562,800.00	316,318,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,290,006,318.21	12,121,972,949.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,290,006,318.21	12,121,972,949.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,605,975,622.23	11,262,146,999.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,956,452,702.00	8,203,189,023.32
210101	Үндсэн цалин	4,502,507,754.00	4,739,235,824.18
210102	Нэмэгдэл	2,108,488,264.00	2,795,598,808.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт		234,813,045.68
210104	Урамшуулал	345,456,684.00	433,541,345.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	864,022,571.00	1,026,455,834.03
210201	Тэтгэврийн даатгал	590,360,365.00	707,686,797.69
210202	Тэтгэмжийн даатгал	72,517,886.00	81,698,559.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,821,976.00	40,335,072.00
210204	Ажилгүйдлийн даатгал	35,533,644.00	38,865,052.00
210205	Эрүүл мэндийн даатгал	128,788,700.00	157,870,353.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,182,614.02	285,109,884.53
210301	Гэрэл, цахилгаан	72,856,638.29	98,438,991.63
210302	Түлш, халаалт	115,662,086.78	109,686,776.90
210303	Цэвэр, бохир ус	63,663,888.95	76,984,116.00
2105	Нормативт зардал	62,248,300.00	91,906,100.00
210502	Хоол, хүнс	62,248,300.00	91,906,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,865,190.00	40,720,610.00
210604	Урсгал засвар	60,865,190.00	40,720,610.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,431,248.16	188,306,049.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,879,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	140,552,148.16	188,306,049.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,249,772,997.05	1,426,459,498.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,376,357.15	398,356,623.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,280,499.80	73,366,808.67
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	817,116,140.10	954,736,066.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	684,030,695.98	859,825,949.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	674,547,200.00	853,657,888.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	545,731,300.00	812,638,488.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,815,900.00	41,019,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,483,495.98	6,168,061.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,483,495.98	6,168,061.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,895,474,647.68	(334,856,096.04)

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	49,496,970.30	118,085,079.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	49,496,970.30	118,085,079.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(49,496,970.30)	(118,085,079.26)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,845,977,677.38	(452,941,175.30)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	11,127,325,100.00	9,820,521,816.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	181,039,800.00	178,963,716.00
120	Нийтлэг татварын бус орлого	181,039,800.00	178,963,716.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	181,039,800.00	178,963,716.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	153,286,100.00	111,645,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,753,700.00	67,318,716.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,946,285,300.00	9,641,558,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,643,722,500.00	9,325,239,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,643,722,500.00	9,325,239,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,562,800.00	316,318,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,562,800.00	316,318,400.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,395,743,624.16	11,112,862,612.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,395,743,624.16	11,112,862,612.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,711,712,928.18	10,252,445,018.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,956,452,702.00	8,203,189,023.32
210101	Үндсэн цалин	4,502,507,754.00	4,739,235,824.18
210102	Нэмэгдэл	2,108,488,264.00	2,795,598,808.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт		234,813,045.68
210104	Урамшуулал	345,456,684.00	433,541,345.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	864,022,571.00	1,026,618,650.69
210201	Тэтгэврийн даатгал	590,360,365.00	707,686,797.69
210202	Тэтгэмжийн даатгал	72,517,886.00	81,698,559.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,821,976.00	40,335,072.00
210204	Ажилгүйдлийн даатгал	35,533,644.00	38,865,052.00
210205	Эрүүл мэндийн даатгал	128,788,700.00	158,033,170.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,182,614.02	285,109,884.53
210301	Гэрэл, цахилгаан	72,856,638.29	98,438,991.63
210302	Түлш, халаалт	115,662,086.78	109,686,776.90
210303	Цэвэр, бохир ус	63,663,888.95	76,984,116.00
2105	Нормативт зардал	62,248,300.00	91,906,100.00
210502	Хоол, хүнс	62,248,300.00	91,906,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,865,190.00	36,000,000.00
210604	Урсгал засвар	60,865,190.00	36,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,186,792.16	188,306,049.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,879,100.00	5,562,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	164,307,692.16	182,743,349.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	331,754,759.00	421,315,310.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	227,242,681.00	364,864,810.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,512,078.00	56,450,500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	684,030,695.98	860,417,593.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	674,547,200.00	854,249,532.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	545,731,300.00	813,230,132.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,815,900.00	41,019,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,483,495.98	6,168,061.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,483,495.98	6,168,061.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,731,581,475.84</u>	<u>(1,292,340,796.04)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	331,762,377.00	225,691,589.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	331,762,377.00	225,691,589.00
2200	Дотоод эх үүсвэрээр	331,762,377.00	225,691,589.00
222001	Тоног төхөөрөмж	275,403,711.00	175,922,657.00
223001	Бусад хөрөнгө	56,358,666.00	49,768,932.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(331,762,377.00)</u>	<u>(225,691,589.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,399,819,098.84	(1,518,032,385.04)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	647,929,047.94	2,047,748,146.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,047,748,146.78	529,516,786.74

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(227,116,523.23)	14,270,906,199.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	(227,116,523.23)	14,270,906,199.64
Тайлант үеийн үр дүн	-	-	1,845,977,677.38	1,845,977,677.38
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	1,618,861,154.09	16,116,883,877.02
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	1,618,861,154.09	16,116,883,877.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	1,618,861,154.09	16,116,883,877.02
Тайлант үеийн үр дүн	-	-	(452,941,175.30)	(452,941,175.30)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,200,550,188.95	10,297,472,533.98	1,165,919,978.79	15,663,942,701.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	2,047,748,146.78	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,635,014,000.00	11,011,475,230.00	623,737,744.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,635,014,000.00	11,011,276,255.04	623,737,744.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,702,756,500.00	10,157,026,723.04	545,729,776.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,601,199,100.00	8,203,189,023.32	398,010,076.68
210101	Үндсэн цалин	5,486,643,300.00	4,739,235,824.18	747,407,475.82
210102	Нэмэгдэл	2,719,936,500.00	2,795,598,808.06	(75,662,308.06)
210103	Унаа хоолны хөнгөлөлт		234,813,045.68	(234,813,045.68)
210104	Урамшуулал	394,619,300.00	433,541,345.40	(38,922,045.40)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,076,906,100.00	1,026,618,650.69	50,287,449.31
210201	Тэтгэврийн даатгал	732,296,100.00	707,686,797.69	24,609,302.31
210202	Тэтгэмжийн даатгал	86,152,500.00	81,698,559.00	4,453,941.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	43,076,300.00	40,335,072.00	2,741,228.00
210204	Ажилгүйдлийн даатгал	43,076,300.00	38,865,052.00	4,211,248.00
210205	Эрүүл мэндийн даатгал	172,304,900.00	158,033,170.00	14,271,730.00
2105	Нормативд зардал	111,600,100.00	91,906,100.00	19,694,000.00
210502	Хоол хүнс	111,600,100.00	91,906,100.00	19,694,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,449,700.00	211,063,049.37	33,386,650.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,400,000.00	5,562,700.00	16,837,300.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	222,049,700.00	205,500,349.37	16,549,350.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	668,601,500.00	624,249,899.66	44,351,600.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	611,374,000.00	567,022,399.66	44,351,600.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,227,500.00	57,227,500.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	932,257,500.00	854,249,532.00	78,007,968.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	932,257,500.00	854,249,532.00	78,007,968.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	891,238,100.00	813,230,132.00	78,007,968.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,019,400.00	41,019,400.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,515,434,000.00	9,493,243,870.00	(6,093,570.00)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,412,280,300.00	9,325,239,700.00	87,040,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	9,412,280,300.00	9,325,239,700.00	87,040,600.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,103,153,700.00	168,004,170.00	(93,134,170.00)

	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.00	111,645,000.00	(111,525,000.00)
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,750,000.00	56,359,170.00	18,390,830.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,028,283,700.00		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,047,748,146.78	2,047,748,146.78
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	529,516,786.74	

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	374,612,400.00	327,277,946.00	47,334,454.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	374,612,400.00	327,277,946.00	47,334,454.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,612,400.00	327,277,946.00	47,334,454.00
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	338,612,400.00	285,109,884.53	53,502,515.47
210301	Гэрэл, цахилгаан	102,970,000.00	98,438,991.63	4,531,008.37
21302	Түлш халаалт	154,536,000.00	109,686,776.90	44,849,223.10
21303	Цэвэр, бохир ус	81,106,400.00	76,984,116.00	4,122,284.00
210604	Урсгал засвар	36,000,000.00	36,000,000.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	374,612,400.00	327,277,946.00	47,334,454.00
	орон нутгийн төсвөөс санхүүжих	359,612,400.00	316,318,400.00	43,294,000.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	10,959,546.00	4,040,454.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 90,842.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд тус сургуулийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Б.Тэрбишийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 3-д “Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус сургуулийн захирал Б.Тэрбиш нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 252,800.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт “Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Байгууллагын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоог мөрдөөгүйгээс нярав болон сэтгэл зүйч албан тушаалд тус бүр 1 орон тоо нэмэгдүүлэн 18,189,033.00 төгрөгийн цалин олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.3-т “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”, сургуулийн захирлын 2025 оны “2025 онд ажиллах бүтэц орон тоо, албан тушаалын жагсаалт батлах тухай” А/01 дүгээр тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

3. Сургуулийн гал тогоог ажиллуулж эхэлсэнтэй холбогдуулан тогооч, туслах тогооч, гал тогооны туслах зэрэг 11 албан тушаалыг байгууллагын бүтэц, орон тоо баталсан тушаалд нэмж батлахгүйгээр томилж, нийт 71,800,716.00 төгрөгийн цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.3-т “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.9-д “Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Санхүүгийн тайлан хүргүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланг хуулийн тогтоосон хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг баримталж, тогтоосон хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх

Дээрх тайлангийн 5.1 дэх хэсэгт дурдсан төлбөрийн акт, 5.2 дахь хэсэгт дурдсан албан шаардлага, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал сургалтын төлбөр төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	
Тайлант онд тус сургуулийн захирал Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	252.8			1	252.8					
Сургуулийн гал тогоог ажиллуулж эхэлсэнтэй холбогдуулан тогооч, туслах тогооч, гал тогооны туслах зэрэг 11 албан тушаалыг байгууллагын бүтэц, орон тоо баталсан тушаалд нэмж батлахгүйгээр томилж, цалин хөлс олгосон байна.	1	71,800.7	-	-	1	71,800.7	-	-	-	-	
Байгууллагын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоог мөрдөөгүйгээс нярав болон сэтгэл зүйч албан тушаалд тус бүр 1 орон тоо нэмэгдүүлэн цалин олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	18,189.0	-	-	1	18,189.0			-	-	
Санхүүгийн тайланг хуулийн тогтоосон хугацаанд аудитын байгууллагад ирүүлээгүй	1	-					1	-			
Дүн	5	90,842.5	1	600.0	1	90,242.5	1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
цалингийн зардлаас бусад 5.0 мянган төгрөгөөс дээш зарлагын 4 гүйлгээний 73,805.1 мянган мэдээллийг байршуулаагүй	1	73,805.1	-	-	1	73,805.1	-	-
Дүн	1	73,805.1	-	-	1	73,805.1	-	-